



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/355

Есөнбулаг

Газар эзэмших эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу газар эзэмших хүсэлт ирүүлсэн 2 иргэний төмс, хүнсний ногооны зориулалтаар эзэмших газрын хэмжээ, байршлыг 1-3 дугаар хавсралтаар баталж, эзэмшүүлсүгэй.


2.Газар эзэмшсэн байгууллагын мэдээллийг Газрын удирдлагын нэгдсэн системд холбогдох журмын дагуу бүртгэн баталгаажуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.

3.Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 2023 оны
35 дугаар сарын 22 ны өдрийн 355 дугаар
захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИГЧИЙН ЭЗЭМШИХ ГАЗРЫН
ЗОРИУЛАЛТ, БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

д/д	Эзэмшигчийн нэр	Иргэн, аж ауйн нэгж байгууллагын регистрийн дугаар	Газар эзэмших ашиглах эрхийн төрөл	Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ (м.кв)	Нэгж талбарын хаяг	Газар эзэмшилтийн зориулалт	Газар эзэмших, ашиглуулах хугацаа
1.	Дашцэрэн Баатарцогт	ДЮ87122318	Эзэмших	3041614	1000	Индэрт баг	1302: Төмс, хүнсний ногооны усалгаатай тариалан	15
2	Баарай Төртөгтох	ДБ885012010	Эзэмших	3041616	1000	Индэрт баг	1302: Төмс, хүнсний ногооны усалгаатай тариалан	15

